СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023 | VIII

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023
8 сар

Баруун-Урт сум

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал.

• Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

- ‘Төл’ гэсэн нь төлөвлөгөө, ‘Гүйц’ гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII, VIII … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-VIII, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		
a^x	x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь		
▲▼	эерэг хандлага, эерэг өөрчлөлт	▲▼	сөрөг хандлага, сөрөг өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

- мянга =1000
- сая $=10^6$
- тэрбум $=10^9$
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- мян. мянга
- % хувь
- кВт.ц киловатт цаг
- ккал килокалори
- $м^2$ метр квадрат
- $км^2$ километр квадрат
- $м^3$ метр куб
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- ш ширхэг

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл 2

Үндсэн үзүүлэлтүүд 5

I Хүн ам 6-7

II Хөдөлмөр 8-9

II Нийгмийн халамж 10

III Эрүүл мэнд 11-13

IV Гэмт хэрэг 14-15

V Мөнгө, банк 16-17

VI Орон нутгийн төсөв 18

VII Үнэ 19-23

VIII Хөдөө аж ахуй 24

IX Аж үйлдвэр 25-28

Хавсралт хүснэгтийн жагсаалт 29

Хавсралт хүснэгтүүд 30-53

БҮЛЭГ	ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:
Үндсэн үзүүлэлтүүд /Хүснэгт/	С.Мөнхбаяр
I Хүн ам	С.Мөнхбаяр
II Хөдөлмөр	Э.Анхцэцэг
III Нийгмийн халамж	С.Мөнхбаяр
IV Эрүүл мэнд	С.Мөнхбаяр
V Гэмт хэрэг	Б. Сумьяа
VI Мөнгө, Банк	Б. Сумьяа
VII Орон нутгийн төсөв	Ц.Азжаргал
VIII.а Хэрэглээний үнэ	Б. Сумьяа
VIII.б Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	С.Мөнхбаяр
IX Хөдөө аж ахуй	С.Мөнхбаяр
X Аж үйлдвэр	Э.Анхцэцэг

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

С.Мөнхбаяр

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 I-VIII	2022 I-VIII	2023 I-VIII
Төрсөн хүүхэд	хүн	934 5.8	710 -23.9	852 20.0
Нялхасын эндэгдэл	хүн	4 -50.0	6 50.0	4 -66.7
Бүртгэлтэй ажилгүйчүүд	хүн	541 0.3	313 -42.1	81 -74.1
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	2561 7.5**	4015 56.8	763 -80.9
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	238 -8.8	387 62.6	338 -12.7
Хэрэгт холбогсод	хүн	164 -23.4	284 73.2	274 -3.5
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	106.7 5.5	108.5 1.7	100.0 -7.8
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	143.0 41.6	135.4 -5.3	136.5 0.8
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	167.4 25.8	198.3 18.5	231.6 16.8
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	48.7 5.2	38.4 -21.1	48.8 27.1
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	43.0 -8.9	35.6 -17.2	32.3 -9.3
Тариалсан талбай: -Төмс	га	84.8 23.1	73.5 -13.3	91.2 24.1
-Хүнсний ногоо	га	51.4 15.5	49.5 -3.7	68.2 37.8
-Үр тариа	га	5 409.0 2.7**	3 599.0 -33.5	4 150.0 15.3
-Тэжээлийн ургамал	га	912.0 78.1	789.0 -13.5	1 251.6 58.6
-Техникийн ургамал	га	3386.0 0.2	2050.0 -39.5	1890.0 -7.8
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	95.2 53.8	101.4 6.5	138.2 36.3
Борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	163.0 62.5	243.5 49.4	292.9 20.3

Тайлбар: ** дахин

ХҮН АМ, жил бүрийн эхний 8 сард



Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 26.0 хувиар өсчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээлээр 2023 оны эхний 8 сард 848 эх амаржиж, 852 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 136 (19.1%)-аар, төрсөн хүүхэд 142 (20.0%)-аар тус тус өсжээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 8 сард



1000 хүнд ногдох төрөлт 12.9 болж өмнөх оноос 2.1 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 8 сард



2023 оны эхний 8 сард нас баралт 205 болж, өмнөх оноос 5 (2.4%)-аар буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 12.9 хувь, нас баралт 3.1 хувь, ердийн цэвэр өсөлт 9.8 хувьтай байна. 1000 хүнд ногдох нас баралт 3.1 болж өмнөх оноос 0.1 нэгж хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР, бүртгэлтэй ажил хайгч иргэд

2023 оны 8 дугаар сард

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 2.4 хувиар буурлаа.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2023 оны 8 дугаар сарын эцэст 81 болсны 43 (53.1%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 232 (74.1%) хүнээр, 2022 оны 12 дугаар сарын эцсээс 282 (77.7%) хүнээр тус тус буурсан байна.
Эхний 8 сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 1097 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 316 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 8 сарын байдлаар



Ажилгүй иргэдийн 66 (81.5%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 16 (19.8%) нь бакалавр, 5 (6.2%) нь мэргэжлийн анхан шат, 34 (42.0%) нь бүрэн дунд, 17 (21.0%) нь суурь, 7 (8.6%) нь бага, 2 (2.5%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшингээр, 8 сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ өмнө оноос 2137 (31.0%) хүнээр буурчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2023 оны эхний 8 сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1423 хүн хамрагдсан нь өмнөх оноос 83 (6.2%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 3206.2 сая төгрөг болж 297.3 (10.2%) сая төгрөгөөр өссөн байна

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2023 оны эхний 8 сард 2310 хүн хамрагдсаны 51.2 хувь нь асаргааны тэтгэмжид, 48.8 хувь нь онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 1803.0 сая төгрөг олгосон нь өмнөх оноос 443.4 (32.6%) сая төгрөгөөр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн эхний 8 сар

Үзүүлэлт	2021 I-VIII		2022 I-VIII		2023 I-VIII	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**26 220**	**6 151.7**	**25 487**	**7 382.6**	**24 056**	**8 290.8**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	9 178	3 473.9	6 820	4 535.9	4 744	5 122.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 256	1 804.2	1 340	2 908.9	1 423	3 206.2
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 137	1 159.4	2 209	1 359.6	2 310	1 803.0
Нийгмийн халамжийн үйлчилгээ	46	30.8	172	60.3	49	39.7
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	5 739	479.5	3 099	207.1	962	73.5
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 470	722.1	5 659	735.7	5 795	747.7
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4 341	85.7	4 669	195.6	4 798	309.3
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	-	-	5	1.4	7	0.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	309	53.8	326	66.1	369	91.9
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	4 174	1 378.6	5 172	1 399.4	5 094	1 519.3
Насны хишиг	2 748	437.6	2 836	448.5	3 249	499.5

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан хүний тоо буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

ЭРҮҮЛ МЭНД, жил бүрийн эхний 8 сард

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид



2022 I-VIII 9 939

2023 I-VIII 10 732

8.0% ↑

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2022 I-VIII 4 015

2023 I-VIII 763

81.0% ↓

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2022 I-VIII 6

2023 I-VIII 4

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2022 I-VIII 4

2023 I-VIII 5

Эхийн эндэгдэл гараагүй.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2023 оны эхний 8 сард 848 эх амаржсан нь өмнөх оноос 136 (19.1%)-аар өссөн байна. Нийт амаржсан эхийн 0.4 хувь нь гэртээ төрсөн байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 807 (95.2%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амалсан, 26 (3.1%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 8 сард

Үзүүлэлт	2021 I-VIII	2022.I-VIII	2023.I-VIII	2023 I-VIII / 2022 I-VIII
	тоо			хувь
Амаржсан эх	925	712	848	119.1
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	855	666	824	123.7
Гэрийн төрөлт	5	2	3	150.0
Амьд төрсөн хүүхэд	934	710	852	120.0
1 цагийн дотор хөхөө амалсан хүүхэд	868	644	807	125.3
төрөлхийн гажигтай төрсөн	7	2	6	3.0 [1]
2500 граммаас доош жинтэй төрсөн	30	21	26	123.8
Амьгүй төрсөн хүүхэд	3	4	4	100.0
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	3.2	5.6	4.7	83.9

2023 оны эхний 8 сард нас баралтын 205 тохиолдол бүртгэгдсэний 42 (20.5%) нь осол гэмтлийн улмаас, 49 (23.9%) нь хорт хавдарын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 8 сард

Үзүүлэлт	2021 I-VIII	2022 I-VIII	2023 I-VIII	2023 I-VIII / 2022 I-VIII
	тоо			хувь
Нас баралт	230	210	205	97.6
Эмнэлгийн нас баралт	42	44	35	79.5
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	25	25	42	168.0
Хорт хавдрын өвчлөл нас баралт	81	62	49	79.0
0-1 насны эндэгдэл	4	6	4	66.7
1-5 хүртэлх насны эндэгдэл	1	4	5	125.0

Халдварт өвчнөөр өвлөгчид 2023 оны эхний 8 сард 763 болж, өмнөх оны мөн үеэс 3252(81.0%)-аар буурахад короновируст халдварын тохиолдол буурсан нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 8 сар

Халдварт өвчин	2021 I-VIII	2022 I-VIII	2023 I-VIII	Өмнөх оны мөн үетэй харьцуулалт	
	хүн			тоо	хувь
Бүгд	**2 561**	**4 015**	**763**	**-3 252**	**19.0**
Вируст гепатит	3	3	3	0	100.0
Гар хөл амны өвчин	19	6	119	113	19.8 [1]
Бруцеллёз	-	1	-	-	-
Цусан суулга	13	13	20	7	153.8
Салхинцэцэг	3	9	202	193	22.4 [1]
Энтервируст халдвар	-	-	104	-	-
Гахай хавдар	-	-	2	-	-
Улаан эсэргэнэ	-	-	13	-	-
Ёлом	-	-	1	-	-
Салмонеллт	-	-	19	-	-
Толбот чичрэг /хачигт/	-	-	4	-	-
Сүрьеэ	33	45	44	- 1	97.8
Тэмбүү	51	32	21	- 11	65.6
Трихомониаз	58	66	42	- 24	63.6
Заг	51	33	37	4	112.1
Ковид-19	2 330	3 807	132	-3 675	3.5

Харин салхинцэцгээр өвчлөгчид 202 (22.4 дахин)-аар, гар хөл амны өвчин 119 (19.8 дахин)-аар нэмэгдэж, Коронавируст халдвараар өвчлөгчид 3675 (96.5%)-гөөр буурсан байна. Шинээр энтервируст халдвар 104, улаан эсэргэнэ 13, ёлом 1, салмонеллт 19, хачигт 4 өвчний халдварын тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 8 сарын байдлаар 178.5 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 19.9 (12.6%) мянган хүнээр өсч, 10.7 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 40.0 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 7.1 (21.7%) мянган хүнээр өсчээ.

Түргэн тусламжийн дуудлага 10.9 мянган удаа гарсны 2.2 (19.8%) мянга нь алсын дуудлага байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ГЭМТ ХЭРЭГ, 2023 оны эхний 8 сард

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2022 I-VIII	2023 I-VIII	
387	338	-12.7% ↓

Хөнгөн хэрэг
282

Хүнд хэрэг
56

Илрүүлэлтийн хувь
44.9%

Гэмт хэргийн улмаас

Гэмтсэн хүн
126

Нас барсан хүн
10

Хохирол сая төг
714.7

Гэмт хэрэг үйлдэгсэд

Бүлгээр
74

Согтуугаар
89

Ял шийтгэгдэж байсан
79

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 49 (12.7%)-өөр буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 10 хүн нас барж, 126 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 714.7 сая төгрөгийн хохирол учирсны 40.6 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 274 хүн холбогдон сэжиглэгдсэний 89 (32.5%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ. Бүлгээр үйлдсэн гэмт хэрэг 8 сард 74 болж өмнөх сараас 65 (86.1%) хүнээр өссөн байна.

Нийт 446 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 49 (12,3%) хүнээр өссөн байна. Нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс 216 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 44.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.5 нэгжээр буурсан байна.

Зураг 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ, ЗЭЭЛ, 2023 оны эхний 8 сард

Мөнгө, эдийн

Нийт зээлдэгчийн тоо

2022 VIII **33 724**

2023 VIII **34 912**

Зээл 2023 VIII

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл **231.6** тэрбум төгрөг

1.8 тэрбум төгрөг — Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл

1.4 тэрбум төгрөг — Чанаргүй зээл

Иргэдийн **136.5** тэрбум төгрөг

Хугацаатай **120.0** тэрбум төгрөг

Хугацаагүй **16.5** тэрбум төгрөг

Салбар нэгжийн тоо **35**

ATM-ны тоо **32**

Ажилтнуудын тоо **208**

Карт эзэмшигчийн тоо **61 595**

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 8 сарын байдлаар 3.4 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.5 хувийг эзэлж байна.

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 231.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 8.0 (3.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 36.3 (18.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 136.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 4.6 (3.3%) тэрбум төгрөгөөр буурсан, өмнөх оны мөн үеэс 1.1 (0.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт хадгаламжийн 87.9% нь хугацаатай, 12.1% нь хугацаагүй хадгаламж байна.

Зураг 6. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАДАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оноос 2.1 дахин өсчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2023 оны эхний 8 сарын байдлаар 48.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 10.4 (27.2%) тэрбум төгрөгөөр өсч, төсвийн зарлага санхүүжилт 32.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.3 (9.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төг



Аймгийн нийт төсвийн 44.3 хувийг орон нутгийн төсвийн орлого, 12.3 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 9.8 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 16.7 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг, 13.1 хувийг урьд оны үлдэгдэл, 3.8 хувийг төсөвт байгууллагуудын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Аймгийн төсвийн мэдээг Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр, хувиар

2023 оны 8 дугаар сард



Тайлбар: Өмнө оны мөн үетэй харьцуулснаар

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай ижил түвшинд байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 8 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 8.7 хувь, өмнөх оны эцсээс 4.8 хувь, өмнөх сараас 0.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 8 дугаар сар өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 5.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 10.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 10.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.2 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 9.0 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 13.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 8 дугаар сард өмнөх оны эцсээс 4.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 2.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 10.9 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 7.1 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 12.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.1 хувиар өсөхөд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 0.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 5. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2023 оны 8 дугаар сард

Бараа үйлчилгээний бүлэг	2023 VIII / 2022 VIII	2023 VIII / 2022 XII	2023 VIII / 2023 VII
	хувь		
Ерөнхий индекс	**108.7**	**104.8**	**100.0**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	116.3	107.9	98.9
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	105.7	103.3	100.4
Хувцас, бөс бараа, гутал	110.3	105.1	100.7
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	103.2	102.3	100.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	110.0	105.1	100.5
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	112.2	110.9	100.0
Тээвэр	99.3	98.3	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.2	100.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	110.1	103.8	100.1
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	109.0	107.1	100.0
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	112.8	112.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	113.8	106.3	100.8

ЗУРАГ 9. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2023 оны 8 дугаар сард өмнөх сараас 8.6 хувиар буурсан байна. Харин өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 17.1 хувь, хонь, ямааны махны үнэ 11.9 хувь, гахайн махны үнэ 10.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд нас гүйцсэн малаас хязаалан гунан үхрийн үнэ хамгийн өндөр буюу 1.7 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2023 оны 08 дугаар сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.3 сая төгрөг болж, 87.5 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.0 сая төгрөг болж, 108.5 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 213.3 мянган төгрөг болж, 10.0 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 1.7 сая төгрөг болж, 360.5 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 136.2 мянган төгрөг болж, 0.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 10. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 8 сард, мянган төгрөг



Хязаалан гунан үхрийн үнэ 2023 оны 08 дугаар сард Түмэнцогт суманд хамгийн их буюу 2.5 сая төгрөг, Баяндэлгэр суманд хамгийн бага буюу 1.0 сая төгрөг байна.

ЗУРАГ 11. ХЯЗААЛАН ГУНАН ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2023 оны 8 сард, мянган төгрөг



Хивэгний үнэ 2023 оны 8 дугаар сард 26.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад хивэгний үнэ 8.0 мянган төгрөгөөр өссөн бол 1 боодол өвсний дундаж үнэ 8.0 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.0 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 12. БООДОЛТОЙ ӨВС, ХИВЭГНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 8 сард



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

Үр тариа 4.2 мянган га-д тариалалт хийсэн байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 оны 8 дугаар сарын байдлаар төмс 91.2 га, хүнсний ногоо 68.2 га, үр тариа 4.2 мянган га, тэжээлийн ургамал 1.3 мянган га, техникийн ургамал 1.9 мянган га-д тариалсан байна.

Үр тариа 4.2 мянган га тариалсанаас 3.1 мянган га улаан буудай, 0.1 мянган га, арвай, 1.0 мянган га овьёос тариалсан байна.

ЗУРАГ 13. НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га



Өмнөх оны мөн үетэй харьцуулхад техникийн ургамал 160 (7.8%) га-аар буурсан бол төмс 17.7 (24.1 %) га-аар, хүнсний ногоо 18.7 (37.8%) га-аар, тэжээлийн ургамал 464.6 (58.9%) га-аар, үр тариа 551.0 (15.3%) га-аар тус тус өсжээ.

ЗУРАГ 14. ХУРААСАН УРГАЦ, тн



Өмнөх оны мөн үетэй харьцуулхад төмс 15 тн-аар буюу 2.6 дахин, хүнсний ногоо 15.5 тн-аар 2.5 дахин өссөн байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2023 оны 8 дугаар сарын байдлаар

Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг



Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг



Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 19.9 хуиар өсчээ.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 138.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 36.8 (36.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 28.8 (34.5%) тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрлэл 6.6 (79.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 112.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 28.8 (34.5%) тэрбум төгрөгөөр өсөхөд чулуун болон хүрэн нүүрс олборлолт 24.7 (34.9 дахин) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 3.7 (6.3%) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолт 0.4 (1.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, хайлуур жоншны баяжмалын олборлолтын биет хэмжээ 53.4 хувиас 14.8 дахин өсчээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт талх, хэвийн боов, бялуу, хэрчсэн гурил, малын мах, бууз банш, бэлтгэлийн хувцас, гутал зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 10.2 хувиас 4.3 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2022 VIII	2022 I-VIII	2023* VIII	2023* I-VIII
		тоо			
Уул уурхай, олборлох аж үйлдвэр					
Хүрэн нүүрс	мян.т	-	31.9	16.9	471.0
Цайрын баяжмал	мян.т	7.8	51.1	5.3	46.3
Төмрийн хүдрийн баяжмал	мян.т	-	40.9	-	-
Хайлуур жонш	мян.т	3.0	17.2	0.8	5.5
Хайлуур жоншны баяжмал	мян.т	2.1	10.2	1.4	15.6
Хайрга, шороо	мян.м3	-	-	-	0.1
Боловсруулах аж үйлдвэр					
Талх	т	49.3	343.3	82.8	378.2
Нарийн боов	т	12.3	61.5	3.6	46.1
Хэвийн боов	т	-	28.3	0.4	46.7
Бялуу	т	0.3	3.9	0.9	4.9
Хэрчсэн гурил	т	0.1	42	7.3	47.0
Малын мах	т	364.1	625.8	446.9	1 056.0
Цэвэр ус	мян.л	102	704.5	28.2	455.0
Бууз, банш	т	1.6	10.7	5.6	20.9
Монгол дээл,тэрлэг	ш	182	1 806	236	1 684
Бэлтгэлийн хувцас /өмд, цамц/	ш	-	14	30	45
Гутал	хос	13	85	16	362

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2023 оны эхний 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 292.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 49.4 (20.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 41.5 (18.4%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн 6.3 7(72.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сая.төг

Салбар	2022 I-VIII	2023*		2023* I-VIII / 2022 I-VIII
		I-VIII	Гадаад	
	тоо			хувь
Нийт дүн	**243 489.9**	**292 913.1**	**139 564.3**	**120.3**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	225 147.2	266 642.6	133 973.4	118.4
Боловсруулах аж үйлдвэр	8 640.1	14 886.6	5 590.9	172.3
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	8 832.4	9 917.3	-	112.3
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	870.2	1 466.6	-	168.5

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 41.5 (18.4%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолтын салбарын борлуулалт 33.8 (47.3 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 16. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг



Гадаад зах зээлд 2023 оны эхний 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 269.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 263.8 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 12.0 хувийг нүүрс олборлолтын салбар, 77.0 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 11.0 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувираа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV ЭРҮҮЛ МЭНД

IV.1 ЭРҮҮЛ МЭНД

IV.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

IV.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

V ГЭМТ ХЭРЭГ

V.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО

V.2 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, сумаар

V.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО

V.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО, сумаар

VI МӨНГӨ, БАНК

VI.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст

VII ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

VII.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

VII.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

VII.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар

VII.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар

VII.5 ОРОН НУТГИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, эдийн засгийн салбараар

VIII ҮНЭ

VIII.а.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

VIII.а.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ

VIII.б МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

IX ХӨДӨӨ АЖ АХУЙ

IX1 ТАРИАЛСАН ТАЛБАЙ, сумаар

IX2 ХУРААСАН УРГАЦ, сумаар

X АЖ ҮЙЛДВЭР

X.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

X.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

X.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

X.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

X.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2021		2022		2023	2023 VIII / 2022 VIII
	I-VIII	I-XII	I-VIII	I-XII	I-VIII	
	тоо					хувь
Нийт дүн	**541**	**563**	**313**	**363**	**81**	**25.9**
Асгат	5	8	5	2	1	20.0
Баяндэлгэр	56	51	6	4	-	-
Дарьганга	12	34	7	3	-	-
Мөнххаан	9	38	24	36	-	-
Наран	12	6	2	10	6	3.0 [1]
Онгон	16	37	13	8	2	13.3
Сүхбаатар	45	48	14	19	1	7.1
Түвшинширээ	46	83	9	72	8	88.9
Түмэнцогт	17	30	7	11	2	28.6
Уулбаян	48	10	9	10	-	-
Халзан	2	15	4	1	-	-
Эрдэнэцагаан	51	32	8	12	10	125.0
Баруун-Урт	222	171	205	175	51	24.9

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Нийт дүн	**81**	**43**	**-**	**16**	**-**	**5**	**34**	**17**	**7**	**2**	**10**	**34**	**22**	**9**	**3**	**3**
Асгат	1	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Баяндэлгэр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Мөнххаан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Наран	6	4	-	2	-	-	2	2	-	-	-	1	3	-	-	2
Онгон	2	1	-	-	-	-	2	-	-	-	-	-	1	-	1	-
Сүхбаатар	1	1	-	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Түвшинширээ	8	6	-	2	-	-	-	4	2	-	1	5	1	1	-	-
Түмэнцогт	2	2	-	1	-	-	1	-	-	-	-	2	-	-	-	-
Уулбаян	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	10	6	-	2	-	1	5	1	-	-	1	4	3	2	-	-
Баруун-Урт	51	22	-	7	-	4	24	10	5	2	7	22	13	6	2	1

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2021		2022		2023	2023 I-VIII / 2022 I-VIII
	I-VIII	I-XII	I-VIII	I-XII	I-VIII	
	тоо					хувь
Нийт дүн	**1 459**	**2 589**	**1 347**	**2 390**	**1 097**	**81.4**
Асгат	57	95	54	126	54	100.0
Баяндэлгэр	92	193	19	30	4	21.1
Дарьганга	101	177	104	136	70	67.3
Мөнххаан	20	96	58	103	4	6.9
Наран	68	98	52	137	68	130.8
Онгон	51	141	20	41	79	3.9 [1]
Сүхбаатар	55	122	49	161	55	112.2
Түвшинширээ	120	258	164	355	178	108.5
Түмэнцогт	58	125	49	64	7	14.3
Уулбаян	72	124	27	82	19	70.4
Халзан	14	39	10	33	-	-
Эрдэнэцагаан	62	103	72	95	89	123.6
Баруун-Урт	689	1 018	669	1 027	470	70.3

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

Сум	2021		2022		2023	2023 I-VIII / 2022 I-VIII
	I-VIII	I-XII	I-VIII	I-XII	I-VIII	
	тоо					хувь
Нийт дүн	**287**	**607**	**268**	**761**	**316**	**117.9**
Асгат	36	52	36	104	49	136.1
Баяндэлгэр	5	35	2	6	1	50.0
Дарьганга	14	30	27	55	50	185.2
Мөнххаан	3	29	19	29	1	5.3
Наран	39	52	31	91	31	100.0
Онгон	7	49	-	17	45	-
Сүхбаатар	17	21	1	56	-	-
Түвшинширээ	36	81	57	153	45	78.9
Түмэнцогт	11	43	19	21	-	-
Уулбаян	2	37	2	38	1	50.0
Халзан	3	10	4	24	-	-
Эрдэнэцагаан	3	7	4	11	66	16.5 [1]
Баруун-Урт	111	161	66	156	27	40.9

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо					Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар										
	2022 I-VIII	2023 I-VIII				Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах аж үйлдвэр	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа
		Бүгд	Байнгын	Түр	Улирал											
Нийт дүн	**327**	**704**	**439**	**247**	**18**	**72**	**114**	**16**	**7**	**23**	**8**	**23**	**420**	**7**	**7**	**5**
Асгат	31	61	28	33	-	14	-	-	-	-	3	8	36	-	-	-
Баяндэлгэр	2	6	-	6	-	-	-	-	-	-	-	-	6	-	-	-
Дарьганга	3	112	69	43	-	11	-	1	-	-	-	3	85	2	7	3
Мөнххаан	37	44	22	17	5	-	-	-	-	4	-	-	40	-	-	-
Наран	18	74	30	39	5	2	-	-	-	1	-	-	70	1	-	-
Онгон	6	15	11	4	-	-	-	1	-	6	-	-	6	2	-	-
Сүхбаатар	32	11	11	-	-	3	-	3	-	1	-	1	-	1	-	2
Түвшинширээ	17	87	49	33	5	13	-	6	-	-	2	8	56	-	-	-
Түмэнцогт	17	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Уулбаян	13	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Халзан	11	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	7	180	131	46	3	6	114	5	7	2	-	-	46	-	-	-
Баруун-Урт	133	114	88	26	-	23	-	-	-	9	3	3	75	1	-	-

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2021 I-VIII		2022 I-VIII		2023 I-VIII	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**26 220**	**6 151.7**	**25 487**	**7 382.6**	**24 056**	**8 290.8**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	**9 178**	**3 473.9**	**6 820**	**4 535.9**	**4 744**	**5 122.4**
Нийгмийн халамжийн тэтгэвэр	**1 256**	**1 804.2**	**1 340**	**2 908.9**	**1 423**	**3 206.2**
